МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

# ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

# 2021-01

2021 оны 03 сарын 01 өдөр

# ГАРЧИГ

1. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ....... 1
1.1. Эрдэс бүтээгдэхүүний экспортын төсөөлөл, гүйцэтгэл ....... 1
1.2. Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл ....... 1
1.3. Уул уурхай, олборлох салбарын төсөвт төвлөрүүлсэн орлого ....... 2
2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР ....... 4
2.1. Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл ....... 4
2.1.1. Уул уурхай, олборлох салбар ....... 4
2.1.2. Хүнд үйлдвэрийн салбар ....... 4
2.1.3. Газрын тосны салбар ....... 4
2.2. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл ....... 6
2.3. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн ....... 7
2.4. Аж үйлдвэрийн салбарт ажиллагсад ....... 8
3. ГАДААД ХУДАЛДАА ....... 9
3.1. Эрдэс бүтээгдэхүүний экспорт ....... 9
3.1.1. Уул уурхай, олборлох салбар ....... 10
3.1.2. Газрын тосны салбар ....... 11
3.1.3. Хүнд үйлдвэрийн салбар ....... 11
3.2. Эрдэс бүтээгдэхүүний импорт ....... 11
3.2.1. Газрын тосны салбар ....... 11

# 1. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ

## 1.1. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ТӨСӨӨЛӨЛ, ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын Сангийн яамны 2021 оны иргэдийн төсөв (ном)-т тусгагдсан хүрэх үр дүн, тоон хэмжээний үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулав.

Эрдэс бүтээгдэхүүний экспортын төлөвлөгөө, гүйцэтгэл (биет хэмжээгээр)

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2021 | | Зөрүү | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлөвлөгөө | 1 сар | | |
| 1 | Нүүрсний экспортын хэмжээг нэмэгдүүлэх | мян.тн | 42,000.0 | 2,522.5 | 39,477.5 | 6.0% |
| 2 | Зэсийн баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх | мян.тн | 1,438.0 | 109.6 | 1,328.4 | 7.6% |
| 3 | Төмрийн хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх | мян.тн | 8,986.0 | 644.6 | 8,341.4 | 7.2% |
| 4 | Алтны олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх (МБ-нд тушаасан)[1] | тн | 20.0 | 1.3 | 18.7 | 6.7% |
| 5 | Газрын тосны экспортын хэмжээг нэмэгдүүлэх | мян.бар | 5,794.0 | 519.3 | 5,274.7 | 9.0% |
| 6 | Цайрын хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх | мян.тн | 119.2 | 11.8 | 107.4 | 9.9% |
| 7 | Хайлуур жоншны хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх | мян.тн | 714.0 | 74.3 | 639.7 | 10.4% |

Эх сурвалж: Сангийн яам, Гаалийн ерөнхий газар, Монголбанк

## 1.2. ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2021 оны 1 сарын гүйцэтгэлээр 711.3 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 56.4 тэрбум төгрөг буюу 7.3 хувиар буурсан байна.

Үүнээс, эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 157.1 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 5.1 тэрбум төгрөг буюу 3.3 хувиар өссөн байна. Төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээ, эзлэх хувийг салбараар харуулав.

- Уул уурхайн салбараас 140.4 тэрбум төгрөг буюу 19.7 хувь,
- Газрын тосны салбараас 14.0 тэрбум төгрөг буюу 2.0 хувь,
- Тусгай зөвшөөрлийн төлбөр 2.4 тэрбум төгрөг буюу 0.3 хувь,
- Бусад орлого 0.2 тэрбум төгрөг буюу 0.1 хувь.

Эрдэс баялгийн салбар[2] нь Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 22.1 хувийг бүрдүүлж байна.

[1] Монголбанканд тушаасан алтны мэдээлэл болно. Тус дунд мөнгөний мэдээлэл ороогүй болно.
[2] Эрдэс баялгийн салбар гэдгийг Уул уурхай, газрын тосны салбараар энэхүү статистик мэдээлэлд оруулсан болно.

Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого, тэрбум төгрөгөөр

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | | Гүйцэтгэл /1 сар/ | | Гүйцэтгэлийн өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2020 (Тодотгол) | 2021 | 2020 | 2021 | Зөрүү | Хувь |
| | Нийт дүн | 2,857.3 | 3,631.9 | 152.0 | 157.1 | 5.1 | 3.3% |
| | УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАР | | | | | | |
| | Нийт дүн | 2,698.1 | 3,396.5 | 128.9 | 140.4 | 11.5 | 8.9% |
| 1 | Алт | 212.6 | 231.0 | 7.5 | 7.1 | -0.4 | -5.1% |
| 2 | Зэс | 1,127.7 | 1,467.0 | 43.7 | 57.8 | 14.2 | 32.4% |
| 3 | Нүүрс | 1,056.3 | 1,337.0 | 64.9 | 49.0 | -15.9 | -24.5% |
| 4 | Бусад | 301.5 | 361.5 | 12.9 | 26.5 | 13.6 | 105.9% |
| | ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР | | | | | | |
| 5 | Газрын тос | 110.0 | 183.2 | 18.4 | 14.0 | -4.4 | -23.7% |
| | ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БОЛОН БУСАД ОРЛОГО | | | | | | |
| | Нийт дүн | 49.2 | 52.2 | 4.7 | 2.7 | -2.0 | -43.3% |
| 6 | Тусгай зөвшөөрлийн төлбөр | 30.0 | 31.2 | 2.4 | 2.4 | 0.1 | 3.1% |
| 7 | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр | 6.6 | 2.5 | 0.1 | 0.1 | -0.0 | -13.7% |
| 8 | Төсөвт байгууллагын өөрийн орлого /СШ-ын орлого/ | 9.0 | 16.0 | | 0.0 | 0.0 | 100.0% |
| 9 | Бусад орлого | 3.6 | 2.5 | 2.3 | 0.1 | -2.1 | -93.8% |

Эх сурвалж: Сангийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Татварын ерөнхий газар

Тайлбар: 1 - дахин их

## 1.3. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАРЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО

2021 оны 1 сарын гүйцэтгэлээр улсын төсөвт 140.4 тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Зэс 57.8 тэрбум төгрөг,
- Нүүрс 49.0 тэрбум төгрөг,
- Төмөр 12.7 тэрбум төгрөг,
- Хайлуур жонш 7.9 тэрбум төгрөг,
- Алт 7.1 тэрбум төгрөг,
- Цайр 4.6 тэрбум төгрөг,
- Бусад ашигт малтмал 1.3 тэрбум төгрөг.

Уул уурхай, олборлох салбараас улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 11.5 тэрбум төгрөг буюу 8.9 хувиар өссөн байна.

Дараах ашигт малтмалын улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй гарсан байна. Үүнд:

- Зэс 14.2 (32.4%) тэрбум төгрөг,
- Төмөр 11.4 (9.9 дахин их) тэрбум төгрөг,
- Хайлуур жонш 7.2 (11.2 дахин их) тэрбум төгрөг,
- Цайр 1.7 (57.7%) тэрбум төгрөг.

Харин дараах ашигт малтмалын улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй гарсан байна. Үүнд:

- Нүүрс 15.9 (24.5%) тэрбум төгрөг,
- Бусад 6.6 (83.4%) тэрбум төгрөг,
- Алт 0.4 (5.1%) тэрбум төгрөг.

### Улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамж, ашигт малтмалаар

тэрбум төгрөг

| Үзүүлэлт | 2020 | 2021 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| | 1 сар | | (3-2)=?, (3/2)=% | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Нийт дүн | 128.9 | 140.4 | 11.5 | 8.9% |
| Алт | 7.5 | 7.1 | -0.4 | -5.1% |
| Нүүрс | 64.9 | 49.0 | -15.9 | -24.5% |
| Цайр | 2.9 | 4.6 | 1.7 | 57.7% |
| Зэс | 43.7 | 57.8 | 14.2 | 32.4% |
| Төмөр | 1.3 | 12.7 | 11.4 | 9.9[1] |
| Хайлуур жонш | 0.7 | 7.9 | 7.2 | 11.2[1] |
| Бусад | 8.0 | 1.3 | -6.6 | -83.4% |

Эх сурвалж: Сангийн яам, Татварын ерөнхий газар

Тайлбар: 1 - дахин их

# 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

## 2.1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

### 2.1.1. Уул уурхай, олборлох салбар

2021 оны 1 сарын гүйцэтгэлээр 4,589.4 мян.тн нүүрс, 108.5 мян.тн зэсийн баяжмал, 701.0 кг алт, 472.0 тн молибдены баяжмал, 11.2 мян.тн хайлуур жоншны хүдэр, 6.0 мян.тн хайлуур жоншны баяжмал, 198.4 мян.тн төмрийн хүдэр, 167.8 мян.тн төмрийн хүдрийн баяжмал, 8.8 мян.тн цайрын баяжмал тус тус үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс 1,718.2 мян.тн буюу 59.8 хувь, зэсийн баяжмал 0.4 мян.тн буюу 0.3 хувь, алт 16.3 кг буюу 2.4 хувь, молибдены баяжмал 33.8 тн буюу 7.7 хувь, төмрийн хүдрийн баяжмал 14.7 мян.тн буюу 9.6 хувь, хайлуур жоншны хүдэр 2.3 мян.тн буюу 25.2 хувь, хайлуур жоншны баяжмал 4.7 мян.тн буюу 4.8 дахин их, цайрын баяжмал 1.0 мян.тн буюу 12.9 хувиар тус тус өссөн байна.

Харин төмрийн хүдэр 10.2 мян.тн буюу 4.9 хувиар буурсан байна.

### 2.1.2. Хүнд үйлдвэрийн салбар

2021 оны 1 сарын гүйцэтгэлээр 550.5 мян.тн баяжуулсан нүүрс, 125.5 мян.тн нүүрсэн шахмал түлш, 800.3 тн катодын зэс, 18.9 тн металл бэлдэц, 418.0 тн ган төмөр хийц тус тус үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад баяжуулсан нүүрс 350.0 мян.тн буюу 2.7 дахин их, нүүрсэн шахмал түлш 55.4 мян.тн буюу 79.1 хувиар өссөн байна.

Харин катодын зэс 103.6 тн буюу 11.5 хувь, металл бэлдэц 2.6 мян.тн буюу 99.3 хувь, металл цувимал 3.7 мян.тн буюу 100 хувь, ган төмөр хийц 304.3 тн буюу 42.1 хувиар тус тус буурсан байна.

### 2.1.3. Газрын тосны салбар

2021 оны 1 сарын гүйцэтгэлээр 525.4 мян.бар газрын тос үйлдвэрлэсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 149.6 мян.бар буюу 39.8 хувиар өссөн байна.

## Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

| № | Бүтээгдэхүүний төрөл | Хэмжих нэгж | 2020 | 2021* | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 1 сар | | (5-3)=?, (5/3)=% | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1. Уул уурхай, олборлолт | | | | | | |
| 1.1 | Нүүрс | мян.тн | 2,871.2 | 4,589.4 | 1,718.2 | 59.8% |
| 1.2 | Газрын тос | мян.бар | 375.8 | 525.4 | 149.6 | 39.8% |
| 1.3 | Зэсийн баяжмал, м/агуулгаараа | мян.тн | 108.1 | 108.5 | 0.4 | 0.3% |
| 1.4 | Молибдены баяжмал, м/ агуулгаараа | тн | 438.2 | 472.0 | 33.8 | 7.7% |
| 1.5 | Алт | кг | 684.8 | 701.0 | 16.3 | 2.4% |
| 1.6 | Төмрийн хүдэр, баяжмал: | мян.тн | 361.7 | 366.2 | 4.5 | 1.2% |
| | - Төмрийн хүдэр | мян.тн | 208.6 | 198.4 | -10.2 | -4.9% |
| | - Төмрийн хүдрийн баяжмал | мян.тн | 153.1 | 167.8 | 14.7 | 9.6% |
| 1.7 | Хайлуур жоншны хүдэр, баяжмал: | мян.тн | 10.2 | 17.1 | 7.0 | 68.5% |
| | - Хайлуур жоншны хүдэр | мян.тн | 8.9 | 11.2 | 2.3 | 25.2% |
| | - Хайлуур жоншны баяжмал | мян.тн | 1.2 | 6.0 | 4.7 | 4.8[1] |
| 1.8 | Цайрын баяжмал | мян.тн | 7.8 | 8.8 | 1.0 | 12.9% |
| 2. Боловсруулах үйлдвэр | | | | | | |
| 2.1. Хүнд үйлдвэр | | | | | | |
| 2.1.1 | Баяжуулсан нүүрс | мян.тн | 200.5 | 550.5 | 350.0 | 174.6% |
| 2.1.2 | Нүүрсэн шахмал түлш | тн | 70,120.0 | 125,559.0 | 55,439.0 | 79.1% |
| 2.1.3 | Катодын зэс, 99% | тн | 903.9 | 800.3 | -103.6 | -11.5% |
| 2.1.4 | Металл бэлдэц | тн | 2,633.4 | 18.9 | -2,614.5 | -99.3% |
| 2.1.5 | Металл цувимал | тн | 3,679.0 | - | -3,679.0 | -100.0% |
| 2.1.6 | Ган төмөр хийц | тн | 722.3 | 418.0 | -304.3 | -42.1% |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тайлбар: 1 - дахин их

## 2.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

тэрбум төгрөг

| Салбар | 2020 | 2021* | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| | 1 сар | | (3-2)=?, (3/2)=% | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Нийт дүн | 1,161.1 | 1,577.0 | 415.9 | 35.8% |
| Уул уурхай, олборлолт | 760.7 | 1,086.3 | 325.6 | 42.8% |
| Нүүрс олборлолт | 239.3 | 496.5 | 257.1 | 107.4% |
| Газрын тос олборлолт | 60.7 | 73.5 | 12.8 | 21.1% |
| Металлын хүдэр олборлолт | 437.5 | 502.7 | 65.2 | 14.9% |
| Бусад ашигт малтмал олборлолт | 8.5 | 11.8 | 3.3 | 38.7% |
| Уул уурхайн туслах үйл ажиллагаа | 14.7 | 1.9 | -12.8 | -87.3% |
| Боловсруулах үйлдвэр | 259.1 | 338.8 | 79.7 | 30.7% |
| Үнэээс, хүнд үйлдвэр | 67.0 | 125.2 | 58.2 | 86.9% |
| Кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 40.5 | 99.0 | 58.5 | 144.4% |
| Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 6.1 | 8.9 | 2.7 | 44.3% |
| Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл | 2.3 | 1.9 | -0.4 | -15.8% |
| Төмрийн үйлдвэрлэл | 17.9 | 15.2 | -2.7 | -15.0% |
| Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл | 0.2 | 0.2 | 0.0 | 14.6% |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тайлбар: 1 - дахин их

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2021 оны 1 сарын гүйцэтгэлээр 1.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 415.9 (35.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 1.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 325.6 (42.8%) тэрбум төгрөгөөр өсөхөд нүүрс олборлолт 257.1 (107.4%) тэрбум төгрөг, металлын хүдэр олборлолт 65.2 (14.9%) тэрбум төгрөг, газрын тос олборлолт 12.8 (21.1%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлөв.

Харин уул уурхайн туслах үйл ажиллагаа 12.8 (87.3%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Уул уурхай, олборлох салбар 68.9 хувийг эзэлж байна.

## 2.3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН

тэрбум төгрөг

| Салбар | 2019 | 2021* | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | 1 сар | | Гад-дад | (4-2)=?, (4/2)=% | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| Нийт дүн | 1,255.2 | 2,080.9 | 1,503.7 | 825.6 | 65.8% |
| Уул уурхай, олборлолт | 704.4 | 1,530.4 | 1,373.7 | 825.9 | 117.2% |
| Чулуун, хүрэн нүүрс олборлолт | 233.2 | 569.0 | 523.1 | 335.8 | 144.0% |
| Газрын түүхий тос, байгалийн хий олборлолт | 46.4 | 72.6 | 72.6 | 26.2 | 56.4% |
| Металлын хүдэр олборлолт | 391.6 | 860.9 | 758.5 | 469.3 | 119.8% |
| Бусад ашигт малтмал олборлолт | 14.2 | 26.9 | 19.5 | 12.7 | 89.3% |
| Уул уурхайн туслах үйл ажиллагаа | 19.0 | 1.0 | | -18.0 | -94.9% |
| Боловсруулах үйлдвэр | 409.2 | 398.5 | 130.1 | -10.7 | -2.6% |
| Үнээс, хүнд үйлдвэр | 186.6 | 138.5 | 105.3 | -48.1 | -25.8% |
| Кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 130.2 | 88.0 | 71.0 | -42.2 | -32.4% |
| Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 6.7 | 9.6 | | 2.9 | 43.3% |
| Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл | 4.5 | 4.7 | | 0.2 | 5.3% |
| Металл боловсруулах үйлдвэрлэл | 45.1 | 36.1 | 34.3 | -9.0 | -19.9% |
| Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 0.1 | 0.1 | | -0.0 | -24.4% |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тайлбар: 1 - дахин их

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2021 оны 1 сарын гүйцэтгэлээр 2.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 825.6 (65.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 1.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 825.9 (117.2%) тэрбум төгрөгөөр өсөхөд нүүрс олборлолтын салбарын борлуулалт 335.8 (144.0%) тэрбум төгрөг, металлын хүдэр олборлолтын салбарын борлуулалт 469.3 (119.8%) тэрбум төгрөг, газрын тосны олборлолтын салбарын борлуулалт 26.2 (56.4%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлөв.

Харин уул уурхайн туслах үйл ажиллагааны салбарын борлуулалт 18.0 (94.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан нийт бүтээгдэхүүнээс 1.5 их наяд төгрөг буюу 72.3 хувийг гадаад зах зээлд борлуулсан байна. Гадаад зах зээлд борлуулсан нийт бүтээгдэхүүний 1.4 их наяд төгрөг буюу буюу 91.4 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн эзэлж байна.

## 2.4. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ АЖИЛЛАГСАД

хүнээр

| Салбар | 2018 | 2019 | 2020 | 2021* | Өөрчлөлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 сар | | | | (5-3)=?, (5/3)=% | | (5-4)=?, (5/4)=% | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| Нийт дүн | 70,864 | 74,673 | 78,566 | 79,107 | 4,434 | 5.9% | 541 | 0.7% |
| Уул уурхай, олборлолт | 21,803 | 22,406 | 23,157 | 24,839 | 2,433 | 10.9% | 1,682 | 7.3% |
| Чулуун, хүрэн нүүрс олборлолт | 7,890 | 8,005 | 7,825 | 7,333 | -672 | -8.4% | -492 | -6.3% |
| Газрын түүхий тос, байгалийн хий олборлолт | 1,493 | 1,569 | 1,544 | 1,398 | -171 | -10.9% | -146 | -9.5% |
| Металлын хүдэр олборлолт | 10,948 | 11,187 | 11,998 | 13,110 | 1,923 | 17.2% | 1,112 | 9.3% |
| Бусад ашигт малтмал олборлолт | 1,472 | 1,533 | 1,644 | 2,802 | 1,269 | 82.8% | 1,158 | 70.4% |
| Уул уурхайн туслах үйл ажиллагаа | - | 112 | 146 | 196 | 84 | 75.0% | 50 | 34.2% |
| Боловсруулах үйлдвэр | 27,727 | 30,176 | 32,886 | 31,976 | 1,800 | 6.0% | -910 | -2.8% |
| Үнэс, хүнд үйлдвэр | 3,656 | 3,478 | 4,767 | 4,078 | 600 | 17.3% | -689 | -14.5% |
| Химийн бодис, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 370 | 513 | 907 | 1,025 | 512 | 99.8% | 118 | 13.0% |
| Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл | 1,639 | 1,274 | 1,943 | 1,277 | 3 | 0.2% | -666 | -34.3% |
| Металл боловсруулах үйлдвэрлэл | 1,559 | 1,602 | 1,837 | 1,685 | 83 | 5.2% | -152 | -8.3% |
| Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 88 | 89 | 80 | 91 | 2 | 2.2% | 11 | 13.8% |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тайлбар: 1 - дахин их

# 3. ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2021 оны 1 сарын байдлаар 1.1 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 166.4 сая ам.доллараар буюу 17.8 хувиар өссөн байна. Экспорт импортоос давамгайлж 181.1 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй гарсан байна.

сая ам.доллар

| Үзүүлэлт | Жилээр | | | Өөрчлөлт 2020/2019 | | 1 сар | | | Өөрчлөлт 2020/2019 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2018 | 2019 | 2020 | Дүн | % | 2019 | 2020 | 2021 | Дүн | % |
| Эргэлт | 12,887 | 13,747 | 12,870 | -877 | -6% | 1,111 | 932 | 1,099 | 166 | 18% |
| Экспорт | 7,012 | 7,620 | 7,576 | -44 | -1% | 607 | 459 | 640 | 181 | 39% |
| Импорт | 5,875 | 6,127 | 5,294 | -833 | -14% | 504 | 473 | 459 | -14 | -3% |
| Тэнцэл | 1,137 | 1,493 | 2,282 | 789 | 53% | 103 | -14 | 181 | 195 | |

## 3.1. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

Эрдэс бүтээгдэхүүний экспорт 568.6 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 131.0 сая ам.доллараар буюу 29.9 хувиар өссөн байна.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, жонш, молибдены баяжмал, боловсруулаагүй нефть, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт, тунгаасан зэс ба хайлш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь нийт экспортын 88.9 хувийг эзэлж байна.

Эрдэс бүтээгдэхүүний экспортын дундаж үнэ

| Барааны нэр | Хэмжих нэгж | 2020 | 2021 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | | 1 сар | | Өсөлт/бууралт | Хувь |
| Чулуун нүүрс | тн/ам.дол | 83.8 | 88.3 | 4.5 | 5.4% |
| Зэсийн баяжмал | тн/ам.дол | 1,122.8 | 1,773.4 | 650.6 | 57.9% |
| Түүхий нефть болон газрын тос | бар/ам.дол | 58.8 | 49.1 | -9.7 | -16.6% |
| Төмрийн хүдэр, баяжмал | тн/ам.дол | 68.0 | 113.4 | 45.4 | 66.7% |
| Цайрын хүдэр, баяжмал | тн/ам.дол | 1,408.8 | 1,502.0 | 93.3 | 6.6% |
| Хайлуур жоншны хүдэр, баяжмал | тн/ам.дол | 273.2 | 214.7 | -58.5 | -21.4% |
| Молибдены хүдэр, баяжмал | тн/ам.дол | 7,043.8 | 6,815.7 | -228.2 | -3.2% |

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

### 3.1.1. Уул уурхай, олборлох салбар

Чулуун нүүрсний экспорт: 2021 оны 1 сарын гүйцэтгэлээр 220.7 сая ам.долларын 2.5 сая тн чулуун нүүрс экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 17.4 сая ам.доллараар буюу 8.5 хувиар, биет хэмжээгээр 73.2 мян.тн-оор буюу 3.0 хувиар тус тус өссөн байна. 1 тн чулуун нүүрсний экспортын дундаж үнэ 88.3 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 4.5 ам.доллараар буюу 5.4 хувиар өссөн байна. Чулуун нүүрсний 92.6 хувийг БНХАУ руу, 7.2 хувийг Сингапур Улс руу тус тус экспортолсон байна.

Зэсийн баяжмалын экспорт: 2021 оны 1 сарын гүйцэтгэлээр 194.3 сая ам.долларын 109.5 мян.тн зэсийн баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 80.2 сая ам.доллараар буюу 70.3 хувиар, биет хэмжээгээр 8.0 мян.тн-оор буюу 7.8 хувиар тус тус өссөн байна. 1 тн зэсийн баяжмалын экспортын дундаж үнэ 1,773.4 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 650.6 ам.доллараар буюу 57.9 хувиар өссөн байна. Зэсийн баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Төмрийн хүдэр, баяжмалын экспорт: 2021 оны 1 сарын гүйцэтгэлээр 73.1 сая ам.долларын 644.6 мян.тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 17.6 сая ам.доллараар буюу 31.8 хувиар өссөн ч, биет хэмжээгээр 170.9 мян.тн-оор буюу 21.0 хувиар буурсан байна. 1 тн төмрийн хүдэр, баяжмалын экспортын дундаж үнэ 113.4 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 45.4 ам.доллар буюу 66.7 хувиар өссөн байна. Төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Хайлуур жоншны хүдэр, баяжмалын экспорт: 2021 оны 1 сарын гүйцэтгэлээр 15.9 сая ам.долларын 74.3 мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 26.8 мян.тн-оор буюу 56.5 хувиар, үнийн дүнгээр 3.0 сая ам.доллараар буюу 23.0 хувиар тус тус өссөн байна. 1 тн хайлуур жоншны экспортын дундаж үнэ 214.7 ам.доллар болж, 58.5 ам.доллар буюу 21.4 хувиар буурсан байна. Хайлуур жоншны 81.6 хувийг БНХАУ руу, 18.4 хувийг ОХУ руу тус тус экспортолсон байна.

Цайрын баяжмалын экспорт: 2021 оны 1 сарын гүйцэтгэлээр 17.7 сая ам.долларын 11.8 мян.тн цайрын баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 984.3 тн-оор буюу 7.7 хувиар, үнийн дүнгээр 287.2 мян.ам.доллараар буюу 1.6 хувиар тус тус буурсан байна. 1 тн цайрын баяжмалын экспортын дундаж үнэ 1,502.0 ам.доллар болж, 93.3 ам.доллар буюу 6.6 хувиар өссөн байна. Цайрын баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Молибдены баяжмалын экспорт: 2021 оны 1 сарын гүйцэтгэлээр 3.3 сая ам.долларын 491.5 тн молибдены баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 458.7 мян.ам.доллараар буюу 12.0 хувиар, биет хэмжээгээр 49.2 тн-оор буюу 9.1 хувиар тус тус буурсан байна. 1 тн молибдены баяжмалын экспортын дундаж үнэ 6,815.7 ам.доллар болж, 228.2 ам.доллараар буюу 3.2 хувиар буурсан байна. Молибдены баяжмалын 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

### 3.1.2. Газрын тосны салбар

Газрын тосны экспорт: 2021 оны 1 сарын гүйцэтгэлээр 25.5 сая ам.долларын 519.3 мян.бар газрын тос экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 231.5 мян.бар-иар буюу 80.5 хувиар, үнийн дүнгээр 8.6 сая ам.доллар буюу 50.6 хувиар тус тус өссөн байна. 1 бар газрын тосны экспортын дундаж үнэ 49.1 ам.доллар болж, 9.7 ам.доллараар буюу 16.6 хувиар буурсан байна.

### 3.1.3. Хүнд үйлдвэрийн салбар

Коксын экспорт: 2021 оны 1 сарын гүйцэтгэлээр 3.5 сая ам.долларын 14.8 мян.тн кокс экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 3.5 сая ам.доллараар буюу 50.4 дахин их, биет хэмжээгээр 14.4 мян.тн-оор буюу 36.0 дахин ихээр тус тус өссөн байна.

Катодын зэс: 2021 оны 1 сарын гүйцэтгэлээр 5.9 сая ам.долларын 760.4 тн катодын зэс экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 200.3 тн-оор буюу 20.8 хувиар буурсан ч, үнийн дүнгээр 201.2 мян.ам.доллараар буюу 3.5 хувиар өссөн байна.

## 3.2. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ

Нийт импорт 2021 оны 1 сарын гүйцэтгэлээр 458.8 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 14.5 сая ам.доллараар буюу 3.1 хувиар буурсан байна.

Эрдэс бүтээгдэхүүний импорт 96.2 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 40.5 сая ам.доллараар буюу 29.6 хувиар буурсан байна.

Эрдэс бүтээгдэхүүний импортын дундаж үнэ

| Барааны нэр | Хэмжих нэгж | 2020 | 2021 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | | 1 сар | | Өсөлт/бууралт | Хувь |
| Автобензин | тн/ам.дол | 632.1 | 445.4 | -186.6 | -29.5% |
| Дизель түлш | тн/ам.дол | 635.7 | 465.5 | -170.1 | -26.8% |

### 3.2.1. Газрын тосны салбар

Эрдэс бүтээгдэхүүний импортын үнийн дүнгийн 84.2 хувийг газрын тосны бүтээгдэхүүн эзэлж байна. 2021 оны 1 сарын гүйцэтгэлээр 81.1 сая ам.долларын 170.4 мян.тн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 18.2 мян.тн-оор буюу 9.7 хувиар, үнийн дүнгээр 40.7 сая ам.доллар буюу 33.4 хувиар тус тус буурсан байна.

Газрын тосны бүтээгдэхүүний импортын нийт үнийн дүнгийн 89.1 хувийг автобензин, дизель түлшний импорт, үүний 26.0 хувийг автобензин, 63.1 хувийг дизель түлшний импорт тус тус эзэлж байна.

Автобензины импорт: 2021 оны 1 сарын гүйцэтгэлээр 21.1 сая ам.долларын 47.3 мян.тн автобензин импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 10.0 мян.тн-оор буюу 17.5 хувиар, үнийн дүнгээр 15.2 сая ам.доллараар буюу 41.8 хувиар тус тус буурсан байна. 1 тн автобензины импортын дундаж үнэ 445.4 ам.доллар болж, 186.6 ам.доллараар буюу 29.5 хувиар буурсан байна.

Дизель түлшний импорт: 2021 оны 1 сарын гүйцэтгэлээр 51.1 сая ам.долларын 109.9 мян.тн дизелийн түлш импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 19.7 сая ам.доллараар буюу 27.8 хувиар, биет хэмжээгээр 1.6 мян.тн буюу 1.4 хувиар тус тус буурсан байна. 1 тн дизель түлшний импортын дундаж үнэ 465.5 ам.долларт болж, 170.1 ам.доллараар буюу 26.8 хувиар буурсан байна.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ